



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,  
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060  
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,  
Цахим шуудан: info@energy.gov.mn

2024.03.22 № 81843

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулгад хариу хүргүүлэх тухай**

Эрчим хүчний яамнаас зарласан ЭХЯ/2024010102 дугаартай, Улсын төсвөөр хэрэгжих Сумын цахилгаан хангамж (Булган, Могод сум)-ийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохын сонирхогч компаниас ирүүлсэн асуултын дагуу дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Асуулт: Тус тендерийн санхүүгийн чадамж хэсэгт (ТШ-3 18.1) заасан 2021,2022,2023 онуудын аль нэг жилд тухайн тендерийн үнийн дүнгийн 50%-с багагүй байна гэсэн байгаа. Манай байгууллагын хувьд 2023 онд Дэлхийн банкны төсөл 2 - н хүрээнд Хэнтий аймгийн 6кВ/0.4кВ-н ЦДАШ, ЦДКШ-н ажилд 380 саяын гэрээ байгуулж ажлаа дуусгасан ба 2023 ондоо санхүүжилтийн 224 сая төгрөг авсан 2024 онд гарснаас хойш үлдэгдэл төлбөрийн санхүүжилт шийдэгдсэн тул 2023 оны санхүүгийн тайланг 263 саяар хаасан. Энэ тохиолдолд байгуулсан гэрээгээ эх хувиар нь хавсаргаад тус тендерт орж болох уу?

Хариулт: Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт (ТШ3 18.2)-д санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичгийг зааж өгсний дагуу Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн [www.ebalance.mof.gov.mn](http://www.ebalance.mof.gov.mn) мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого болон бусад шаардлагатай мэдээллийг цахим системээр дамжуулан шалгах тул тухайн системд тайлагнасан дүнгээр борлуулалтын орлогыг тооцно.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Н.ТАВИНБЭХ

170600000750